

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**  
**“МОНГОЛ СУДЛАЛ”**  
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234736

**ӨВӨР МОНГОЛД ДЭЛГЭРСЭН “ШҮЙХУ-ГИЙН ҮЛГЭР”-ИЙН  
МОНГОЛ ОРЧУУЛГЫН ШИНЖЛЭЛ**

Дагуул  
Жинь Рүн

**Товч агуулга:** Тус өгүүлэлд Мин улсын сүүлч үеэр зохиогдсон “Шүйху-гийн үлгэр” хэдий үеэс монгол хэлэнд орчуулагдаж эхэлсэн, өвөр монгол оронд бичгийн хэлбэрээр хэрхэн уламжлагдан дамжиж ирсэн байдлыг: Чин улсын сүүлч үеийн бичгийн орчуулга, дэлгэрэл; ХХ зууны эхэн үеийн бичгийн орчуулга, дэлгэрэл; ХХ зууны хоёрдугаар хагасаас хойших бичгийн орчуулга, дэлгэрэл гэсэн гурван шат хувааж, хэлэлцэх юм. Үүнд, Чин улсын сүүлч үеэс гар бичмэл хувилбараар нэлээд идэвхтэй дэлгэрэн түгэж байсан 100 бүлэгт, 120 бүлэгт “Шүйху-гийн үлгэр”-ийн монгол орчуулга, ХХ эхэн үед дэлгэрсэн чулуун барын хувилбар, ХХ зууны жар далаад оноос нааш голдуу монгол орчуулгын дэвтрийг дахин хэвлүүлэх буюу цомхотгон найруулж зурагт дэвтрийн хэлбэрээр түгээсэн хувилбаруудын тус тусын онцлогийг авч үзнэ.

**Түлхүүр үг:** “Шүйху-гийн үлгэр”, монгол орчуулга, бичгийн уламжлал

**Удиртгал**

“Шүйху-гийн үлгэр” бол Мин улсын сүүлч үеэр зохиогдсон, Хятад улсын эртний алдарт дөрвөн сонгодог бүтээлийн нэг бөгөөд сүүлийн хэдэн зуун жилийн турш хөрш зэргэлдээ олон орны хэлээр орчуулагдаж, дорно дахин ба өрнө дахины улс үндэстний хоорондох соёлын солилцоог ахиулсаар иржээ. Тус бүтээл Чин улсын сүүлч үеэс монгол хэлэнд орчуулагдаж Өвөр монгол болон Монгол улсад дэлгэрэн тархаж эхэлсэн юм. Энэ удаад бид монгол орчуулгын “Шүйху-гийн үлгэр”-ийн Өвөр Монгол дахь бичгийн уламжлал, шинэчлэлтийн байдлыг авч хэлэлцэх юм.

**1. Чин улсын сүүлч үеийн бичгийн орчуулга, дэлгэрэлт:** Зохиогчийн хийсэн хээрийн шинжилгээний ажлын хэрэглэгдэхүүн хийгээд “Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг” (Үүрийнхяраа 1999) бүтээлээс үзвэл, монгол орчуулгын “Шүйху-гийн үлгэр” Өвөр Монгол оронд анхлан дэлгэрэхдээ голдуу гар бичмэлийн хэлбэрээр уламжлан тархаж байжээ. Үүнийг Өвөр Монголын Их Сургуулийн номын сан, Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн номын сан, Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн, Өвөр Монголын номын сан, Харчин зүүн гарын монгол үндэстний өөртөө засах шяны данс эвхмэлийн

сан, Улаанхадын үндэстний хэрэг эрхлэх зөвлөлийн эртний ном бичгийн албан гэр, Үндэстний хэвлэлийн хорооны материалын тасагт хадгалагдаж хувилбарууд бүгд гар бичмэл байгаагаас харж болохоор байна. Дэлгэрүүлэн танилцуулбал:

1.1. Өвөр Монголын Их сургуулийн номын сан дахь гар бичмэл: Тус дэвтэрлэсэн “Шүйху жуаны бичиг” гэдэг орчуулга нь 100 бүлэгтэй, орчуулагч нь тодорхойгүй, хар бэхээр, бийрээр хичээнгүй бичжээ. Дэвтрийг утсаар үdsэн, өндөр нь 26 см, өргөн нь 23.5 см, 3 дугтуйтай, бүгд 12 дэвтэр болно.

1.2. Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн номын сан дахь гар бичмэл: Тус дэвтэрлэсэн “Шүйху жуаны бичиг” гэдэг орчуулга нь 120 бүлэгтэй, орчуулагч нь тодорхойгүй, хар бэхээр бийрээр хичээнгүй бичигдсэн. Дэвтрийг утсаар үdsэн, өндөр нь 30.3 см, өргөн нь 26.3 см, 3 дугтуйтай, дугтуй бүрд 2 дэвтэр, бүгд 6 дэвтэр бий.

1.3. Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх ухааны хүрээлэн дэх гар бичмэл: Тус дэвтэрлэсэн “Шүйху жуаны бичиг” гэдэг орчуулга нь 120 бүлэгтэй, орчуулагч нь тодорхойгүй, хар бэхээр бийрээр таталган тигээр бичигдсэн. Дэвтрийг утсаар үdsэн, өндөр нь 23.5 см, өргөн нь 26.3 см, хорин тавдугаар дэвтэр нь дутуу, нийт 39 дэвтэр бий .

1.4. Харчин зүүн гарын монгол үндэстний өөртөө засах шяны данс эвхмэлийн сан дахь гар бичмэл: “Ерөнхий гарчиг” дахь тэмдэглэлийг үндэслэвэл, Харчин зүүн гарын монгол үндэстний өөртөө засах шяны данс эвхмэлийн санд хоёр зулийн 120 бүлэгт “Шүйху жуаны бичиг” хадгалагдаж байна. Үүний нэг нь Чин улсын сүүлчийн үеийн гар бичмэл, нөгөө нэг нь XX зуны эхэн үеийн гар бичмэл болно. Аль алины нь орчуулагч тодорхойгүй. Чин улсын сүүлчийн үеийн 120 бүлэгт гар бичмэл нь гүехэн шар өнгийн хавтастай, бийрийн бичмэл дэвтэр. Өндөр нь 27.5 см, өргөн нь 21 см, утсан үdmэл, оршил гаргалга үгүй. Хөмсөгний цохолбор, хавчуулсан цохолбор хийгээд бүлгийн арын ерөнхий цохолборгүй. Дотор агуулгын нүүр бүрд 12 мөртэй, 20 дэвтэр хадгалагдаж буй. Орчуулагч нь тодорхойгүй (Чи Ли нар. 2019: 108).

1.5. Улаанхадын үндэстний хэрэг эрхлэх зөвлөлийн эртний ном бичгийн албан гэр дэх гар бичмэл: Тус гар бичмэлийн орчуулагч нь тодорхойгүй, оршил гаргалга үгүй, хөмсөгний цохолбор, хавчуулсан цохолбор хийгээд бүлгийн арын ерөнхий цохолборгүй, нүүр бүрд 13 мөртэй, Чин улсын сүүлчийн үеийн бийрийн бичмэл дэвтэр болно. Өндөр нь 23 см, өргөн нь 23.4 см, утсан үdmэл, нэг л дэвтэр үлджээ.

1.6. Үндэстний хэвлэлийн хорооны материалын тасаг дахь гар бичмэл: Тус гар бичмэл нь нийт 120 бүлэгтэй, 33 дэвтэр хадгалагдаж байна. Чин улсын сүүлчийн үеийн бийрийн бичмэл, өндөр нь 25.5 см, өргөн нь 18 см, утсан үdmэл дэвтэр болно .

Өвөр Монгол оронд хадгалагдаж байгаа тэдгээр монгол орчуулгын гар бичмэлийн байдлаас үзвэл, Чин улсын сүүлч үеэс голдуу 100 бүлэгт, 120 бүлэгт “Шүйху-гийн үлгэр” гар бичмэлийн хэлбэрээр идэвхтэй дэлгэрэн тархаж байсан нь гарцаагүй. Чин улсын сүүлч үеийн Өвөр Монгол орны нийгмийн нөхцөл байдлаас үүдэн хятад хэлний сонгодог бүтээл монголоор орчуулагдсаны дараа гар бичмэлийн хэлбэрээр дэлгэрч, энэ нь хүмүүсийн сонирхлыг ихэд татсан учир нэг нэгнээсээ зээлэн унших буюу дахин дамжуулан хуулах ажиллагаа олширч,

нийгүйн нөлөө тусгал нь улмаар өргөжжээ. Гэвч, энэ үед голдуу хүмүүсийн хоорондох харилцаанд түшиглэн бие биеэс зээлэх буюу дахин хуулах хэлбэрээр тархаж байсан нь тухайн бичгийг гарган уншихад удаан, мөн хуулан бичихэд цаг хугацаа нэлээд ордог, хүмүүсийн харилцааны хүрээ цараа хязгаарлагдмал, гар бичмэлийг хадгалахад дөхөмгүй зэрэг хүндрэлтэй байв. Ийм байдлаас болж тархалт нь ч бас хожим хойчийн үеэс бага байжээ.

**2. ХХ зууны эхэн үеийн бичгийн орчуулга, дэлгэрэл.** Энэ үеийн Өвөр Монголд “Шүйху-гийн үлгэр” нь гар бичмэлээр үргэлжлэн дэлгэрэхийн зэрэгцээ чулуун бараар хэвлэгдэн тархах болжээ. Үүнийг “Ерөнхий гарчиг” дахь тэмдэглэлээс үзэж болно. Тухайлбал, Харчин зүүн гарын монгол үндэстний өөртөө засах шяны данс эвхмэлийн санд ХХ зууны эхэн үеийн нэг зүйлийн гар бичмэл хадгалагдаж байгаа ажээ. Энэ нь 120 бүлэгтэй, 20 дэвтэр хадгалагдаж байна. Өндөр нь 26 см, өргөн нь 19 см, утсан үдмэл дэвтэр, орчуулагч нь тодорхойгүй. Энэ нь тухайн үед “Шүйху-гийн үлгэр” гар бичмэлийн хэлбэрээр үргэлжлэн тархаж байсныг харуулна (Чи Ли нар. 2019: 109).

Харин чулуун барын хэвлэлийн хувьд одоогоор Өвөр Монголын номын санд хадгалагдаж байгаа 100 бүлэгт “Шүйху-гийн үлгэр” болно. Тус хэвлэлийн орчуулагч нь тодорхойгүй, Дундад иргэн улсын үеийн Кайлү дахь монгол утгын сургаалын хурлаас барлан хэвлүүлжээ. 1-36 дугаар бүлэг хадгалагдаж байна. Энгийн хавтастай, хар өнгийн хичээнгүй тигийн чулуун барын хэвлэмэл дэвтэр бөгөөд өргөн нь 18.3 см, өндөр нь 25.5 см болно. Номын хавтас гүехэн шар өнгөтэй, хавтасны баруун хөвөөг дагуулж зурсан, дөрвөн өнцөгтөө угалз хээтэй, хар давхар хүрээт дөрвөлжин дотор улаан өнгийн дэвсгэр дээр “Шүйху үлгэр” (“Шүй”-ийг манж үсгээр бичсэн) гэж хар үсгээр номын нэрийг бичжээ. Номын эхний нүүрийн зүүн дээд өнцөгт “Шүйху-гийн бичиг” (“Шүйху” гэх нэрийг манж үсгээр бичсэн) гэж жижиг үсгээр бичиж, зүүн доод өнцөгт дэвтрийн дугаарыг бичиж, залгуулаад дараагийн мөрөөс нь тус дэвтэр дэх бүлгийн гарчгийг жагсааж бичжээ. Номын арын нүүрийн голд Монгол утгын сургаалын хурлын тэмдгийг тамгалсан ажээ.

Монгол утгын сургаалын хурлаас “Шүйху-гийн үлгэр”-ээс гадна “Хөх монголын хөх туг”, “Японы сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл”, “Мигуйн туршигч”, “Шинэ үсгийн толь” зэрэг дөчөөд зүйлийн монгол номыг хэвлүүлэн тархаажээ. Тухайн үед Кайлүд хүрч, эдгээр хэвлэл дармалын байдлыг нүдээрээ үзсэн Германы монголч эрдэмтэн В.Хайссиг, “Тэдний ажил бол цэвэрхэн гэгч хуулан бичээд, хэдэн мянган цаг хэрэглэж сайтар дармаллаж гаргаад, бас хуучирч урагдсан уг эхийг эрж олох явдал байв. Үнэхээр тийм амар ажил биш байлаа. Хуудас бүрийг гар бичмэлийн хэлбэрээр цаасан хэв дээр цэвэр сайхан бичээд, бас хуудас нэг бүрийг гараараа хэдэн зуун удаа дармаллаж гаргана гэдэг бол нэлээд хүнд ажил байх нь зайлшгүй юм” (Мандах 2019: 67) хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү номыг хэвлэн дэлгэрүүлэх болсон нь өмнөх гар бичмэлээр тарах байдалтай харьцуулбал, хэвлэн дармаллах тоо нь олширч, хэвлэлийн мэргэжлийн хувьд нэлээд дэвшил гарснаас гадна тусгай зохион байгуулалттайгаар тархааж, харьцангуй олон хүнд хүргэх болжээ (Туяа 2010: 404).

**3. ХХ зууны жар далаад оноос хойш монгол орчуулгын “Шүйху-гийн үлгэр”-ийн Өвөр Монгол дахь түгэн дэлгэрэл.** Энэ үед ч мөн гар бичмэл хувилбар гарч байсныг Өвөр Монголын Номын санд хадгалагдаж буй ХХ зууны жараад оны үеийн хоёр зүйлийн “Шүйху-гийн үлгэр”-ийн гар бичмэлээс харж болно. Гэвч, энэ үед гарсан гол өөрчлөлт бол харьцангуй хөгжсөн хэвлэлийн төхөөрөмжөөр ном болгон хэвлэж урьд өмнөх үеийнхээс илүү хурдтайгаар, илүү олноор уншигчдад хүргэх болсон явдал юм. Улмаар энэхүү хөгжилтийг ХХ зууны далаад оны үеийн хорголжин барын хэвлэмэл ном хийгээд хожим үеийн электрон барын хэвлэмэл ном гэж хоёр ялгаж ч болно. Тухайлбал, 1976 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос “Шүйху-гийн үлгэр”-ийг шинээр орчуулж хорголжин бараар хэвлүүлж, хэд хэдэн удаа дахин засварлан хэвлэжээ. Түүнчлэн, сүүлийн үед компьютероор эх бэлтгэн олон мянган хувиар дахин хэвлэх болжээ. Нэгэн жишээ гэхэд, “Шүйху-гийн үлгэр”-ийн хятад эхийг Ван Ичиний цомхотгосон хувилбарыг, Саранчимэг монголчилж 2013 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос 10000 хувь хэвлэжээ.

#### **4. “Шүйху-гийн үлгэр”-ийн Өвөр Монгол дахь түгэн дэлгэрэлтийн онцлог**

4.1. Монгол орчуулгын эхийн олон эх сурвалжит шинж: Чи Жи, Жү Бао нар “Шүйху-гийн үлгэр” нь Чин улсын үед багадаа дөрвөн зүйлийн монгол орчуулгатай байжээ гэж дурдсан юм. Энэ нь монгол орчуулгын “Шүйху-гийн үлгэр”-ийн Өвөр Монгол орон дахь бичгийн дэлгэрэл нь нэг эхээс хуулагдаж, адилхан хэв байдалтайгаар өргөжин тархсан биш, харин олон эхээс эх сурвалж авч, өөр өөрийнхөө замаар уламжлагдан тархжээ. Ингэснээр аль нэг хувилбар явцын дунд дундаасаа гээгдэж алга болоход нөгөө хувилбаруудаас нөхөн гүйцээх, хятад-монгол орчуулгын уламжлалыг харьцуулан судлах зэрэгт ач холбогдолтой болсон байна. Тухайлбал, 1977 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос хорголжин бараар хэвлүүлэхдээ Өвөр Монголын Номын санд хадгалагдаж байсан эхүүдийг харьцуулан үзэж, бие биеэс харилцан нөхөж, бүр дутсан зарим хэсгийг хятад хэвлэлээс шинээр орчуулан гүйцээж хэвлэж байжээ (Люй Гуанжүн нар. 1975: 3).

4.2. Бүтээлчээр орчуулах хийгээд уншигчдад зохицуулах шинж: Дээр дурдсанчлан хэд хэдэн газар хадгалагдаж буй монгол орчуулгын “Шүйху-гийн үлгэр”-ийн олонх нь уг хятад зохиолын шууд орчуулга биш, харин уг зохиолыг ямар нэгэн хэмжээгээр нэмэх буюу хасах байдлаар монгол уншигчдад зориулан найруулсан эхүүд байх ажээ. Өөрөөр хэлбэл, уг эхэд суурилан, уран зохиолын агуулга, ерөнхий бүтцийг анхаарсан боловч бас орчуулагчийн мэдлэг чадвар, түүнийг хүлэн авагч монгол уншигчдын өвөрмөц онцлогт тохируулж, зарим хэсгийн агуулгыг цомхотгосон, эсвэл бүхий л агуулгыг хураангуйлан цомхотгох аргаар орчуулан дамжуулсан онцлог тодорхой илэрч байна. Бүр, хүүхэд багачуудад зориулсан “Шүйху-гийн үлгэр”-ийн зурагт дэвтэрт гэхэд түүхт шинж, сонирхолт шинж, хүмүүжүүлэх шинж чанартай хэсгийг сонгон авч харин бусад хэсгийг орхисон байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, хэдэн зууны турш “Шүйху-гийн үлгэр”-ийг монголчлон тархаахдаа уг хятад эхэд шүтэх биш харин өөрийн хэрэгцээнд нийцүүлэн үйлдэх бүтээлч хандлагыг баримталж иржээ.

## Дүгнэлт

Хятад улсын эртний алдарт дөрвөн сонгодог бүтээлийн нэг “Шүйху-гийн үлгэр” нь анх зохиогдсон цагаасаа эхлэн хэдэн зуун жилийн турш хөрш зэргэлдээ олон орны хэлээр орчуулагдаж, дорно дахин ба өрнө дахины улс үндэстний хоорондох соёлын солилцоог ахиулсаар иржээ. Тус бүтээл Чин улсын сүүлч үеэс монгол хэлэнд орчуулагдаж Өвөр Монгол болон Монгол улсад дэлгэрэн тархаадаа тухайн үеийн Өвөр Монголын нийгэм, эдийн засаг, технологийн хөгжлөөс шалтгаалж нэлээд хугацаанд гар бичмэлээр дэлгэрчээ. Ийнхүү түгэх явцдаа нэг хувилбар нь негеө хувилбartaа нөлөөлж, уг зохиол монголжин хувьсан хөгжиж, янз бүрийн хувилбар үүсэх замаар түгэн дэлгэрсэн байна. Энэ явцад нийгмийн хувьсал хөгжил, монголчуудын мэдлэг боловсролын түвшин нэмэгдэхийг дагалдан тухай тухайн цагийн уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн засварлан найруулах, зураг чимэглэл, тайлбар зүүлтээр баяжуулах зэрэг бүтээлч хандлагыг тусгаж иржээ.

## Ном зүй

- Люй Гуанжун нар. (1977) Шүйху жуаны бичиг (эртний орчуулга). Өвөр Монголын өөртөө засах орны Хувьсгалын зөвлөлийн монгол хэл утга зохиол түүх судлах газар (монгол бичгээр).
- Мандах (2019) Соён гэгээрүүлэгч Бөххэшиг. Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо (монгол бичгээр).
- Туяа, Ү. (2010) Монгол хэвлэлийн түүх. Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо (монгол бичгээр).
- Үүрийнхяраа (1999) Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг. Бээжингийн номын сан хэвлэлийн хороо (монгол бичгээр).
- Чи Ли нар. (2019) 齐季、聚宝：‘水浒传’ 清季蒙古文诸本汇论，内蒙古师范大学学报.

## Abstract

‘Shui Hu’ was translated into Mongolian during the late Qing Dynasty and began to be disseminated in Inner Mongolia in written form. Based on the changes and advancements in the dissemination of the Mongolian-translated version of ‘Shui Hu’ in Inner Mongolia, it can be divided into three periods: the late Qing Dynasty period characterized by written dissemination, the Republican era period characterized by written dissemination, and the period since the 1960s and 1970s characterized by written dissemination. During the late Qing Dynasty, handwritten versions of the Mongolian-translated edition of ‘Shui Hu’ actively circulated, with around 100 to 120 handwritten copies in existence. In the Republican era, lithographic editions of the book enjoyed widespread dissemination. Since the 1960s and 1970s, the reprints or simplified versions of the Mongolian-translated edition have predominantly been disseminated in the form of pictures. The written dissemination of ‘Shui Hu’ exhibits unique characteristics, including diverse versions, creative translation techniques, various editions, and a focus on catering to readers demands.

**Keywords:** Shui Hu, Mongolian-translated Version, Written Dissemination